

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Даваа	Дугаар	L223
Оршин суугаа аймаг	Булган	Оршин суугаа сум	Рашаант сум
Төрсөн газар	Рашаант сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Одоогийн сүм хийд	Хөгнө тарны хийд	Сүм хийдийн дугаар	БУРТ 005, БУРТ 004
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 20	Ярилцлага авсан хүн	Ц.Мөнхбат



Булган аймгийн Рашаант сумын Өвгөн хийд буюу Хөгнө тарны хийд Мөнхбат:Судалгааны баг 2007 оны 7-р сарын 20-ны өдөр Булган аймгийн Рашаант сумын 2-р багийн нутаг, Монголын нууц товчоонд Ханхархаан нэрээр нэрлэгдэж байсан Монголын түүх соёл байгаль цаг уурын томоохон цогцолбор дурсгалуудыг хадгалсан Хөгнөхаан уулын өвөр бэл дэх Монголын буддын шашны түрүү үеийн хөгжилд хамаарагдах эртний түүхтэй Өвгөн хийд буюу Монголчуудын дунд Хөгөнөтарны хийд гэж алдаршсан хийдийн туурин дээрээс судалгааны ажлаа үргэлжлүүлж байна. Манай энэ судалгааны багийн ажилд Өвгөн Тарны хийдийн түүх домог,үүсэл хөгжил, сэргэн мандалт, мөхөлтийн талаар мэдээлэл, ярилцлага өгөхөөр энэ хийдийн орчин цагийн өнгө аяс дор сэргээн босгосон Эрдэнэхамбын хийдийг үүсгэн байгуулагч өндөр настан Даваа гуайтай энэ ярилцлагыг хийсэн юм. Танд дараах 2 асуултын тавьмаар байна. 1-рт тухайн үеийн Түшээт хан аймгийн Бишрэлт гүний хошуу буюу одоогийн Булган аймгийн Рашаант сумын нутагт байдаг 700 гаруй жилийн түүхтэй энэ Өвгөн хийдийн гарал үүслийн талаар үлгэр домог, түүхийн хуудаснаас

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

багагүй мэдээлэл байдаг. Таны хувьд хуучуулаас өвөг дээдсээс сонсож үлдээсэн ямар мэдээлэл байна вэ?

Даваа:Өөрийн өвөг эцэг, өөрийн эцэг энэ түүхийн тухай жаахан байхад ярьж өгч байсан. Энэ өвгөн хийд бол дээр үеийн, 14 зууны хийд шиг байна лээ. Урд Ландарма хаан гэж шашныг устгаж байсан юм байна лээ Эннэтхэг улсад, түүнийг дараад Халанбуу Балдорж гэдэг хүн бол наашаа зугтаж Гүнбүмд байж байгаад дамжаад ирэхэд Хаан уулыг чинь Жамсран гэдэг юм, Жамсран тэр дагинатайгаа, дагина нь ч юм уу даа энэ Хөгөн арна гэдэгтэйгээ дөхөж очсон гэдэг юм. Тэгээд Хөгшин хийд дээр байж байгаад шашныг оруулж ирж энэ Өвгөн хийдэд, хийд барьж олон лам нар оруулж хурал хурж байсан. Тэгээд манай Галданбошигт анхны богд Занабазар хоёр хоёулаа урд ном сурч ирээд, Манж улс үймүүлээд, Манжийн юунд орно орохгүй гэж, Занабазар орно гээд, Галданбошигт орохгүй гээд жаахан маргалдсаны эцэст Богдыг бариулах гээд Галданбошигт цэрэг мордуулаад тэгээд олдоогүй, алтан ганжуураа юмаар бүтээсэн байсанд, тэгээд явчихлаа гээд бодоод алтан ганжуурынхаа бүтээлгийг автал Эрээний нуруу дээрээс дурандаад алтан гажуур нь харагдахаар нь эргэж ирээд лам нарыг нь хөгөнөжил гэж, толгойг нь аваад хийдийг нь сүйтгэчихсэн юм байна лээ. Тэрний дараа Эрдэнэ хамба бол Богдын жатий хамба гэж багш нь байсан. Тийм учраас багш нь хийдгүй болчихлоо гээд Залуу хийдийг барьж өгөөд 60 айл тасдаж өгөөд ингээд энэ хийдийг байгуулсан. Гэтэл Ардын Засаг гараад бас лам нарыг нь Архангайд аваачиж буудаж алаад хүрээ хийдийг нь юу ч үгүй болгоод. 70аад жил манайхан чинь бурхан сахиус тахихгүй тийм байсан тэгээд Ардчилал шинэчлэл гэж нэг ийм гараад хүн бүхэн юм хий, ээж аавынхаа юмыг сэргээж болноо гэхээр нь миний өвөг эцэг захиж байсан юм Дэндэв гэж хүн байсан юм. “Эрдэнэзуу энэ хийдээс алс нь утаа гарах юм байгаа юм, тэр үед чи чадал тэнхээ байх юм бол энэ хийдийг мэргээхэд гар бие оролцоорой” гэж захиж байсан. Би ч тэр үед жаахан хүүхэд байсан. Худлаа хэлж байна даа, юу ярьж байгаа юм бол гэж бодож байсан. Гэтэл Ардчилал шинэчлэлийн үед хүн бүр хийдээ гаргах гээд ирэхээр би Улаанбаатар хотоос ирээд энэ хийдээ гаргах гээд ирээд байж байна. Түүх нь бол ийм л юм байгаа юм.

Мөнхбат:Түүх сударт өгүүлснээр МЭ 9-р зууны амьдарч байсан төвд лам Балдорж Эрдэнэхамбын хийдийн үүсэл гарал их салшгүй холбоотой гэсэн байдаг. Тэр Лхалам гэдэг хүн Ямандагийн бясалгалыг хийгээд ар халхын нутагт аглагт сууж байх хойгуур нь Төвдөд Ландарма гэдэг хаан гарч Төвдийн Буддын соёлыг устгасан. Энийг сонссон Лха лам Төвддөө буцаж очоод Ландарма хааныг устгажээ гэж. Ингээд тэнд байх боломжгүй болоод энд ирж энэ Ханхархаан ууланд ингэж суурьшсанаар Эрдэнэхамбын хийд гэсэн энэ Түшээт хан аймгийн энэ хошууны алдартай хийд үүссэн гэж түүх домогт байдаг. Таны аав бурханы шашны ямар зиндаатай хуврага явсан юм бол? Ямар ямар хүрээ хийдэд шавилан сууж байсан тийм тал байна уу?

Даваа:Намайг жаахан байхад л өндөр настай хүн байсан, тэр бариа тавианд орохгүйгээр 80 гарсан хүн байсан. Урьд нь хаана сууж байсныг сонирхоогүй, жоохон ч байсан тэгээд өөрөө бол тэр хийд дээр, авгай байхгүй, манай аавыг бол дүүгээсээ өргөж авсан, энэ хийд дээрээ насыг барсан хүн. Түүхийг бол их судалдаг хүн байжээ, одоо бодож байхад.

Мөнхбат:Та түрүүн ярилцлагадаа дурдаад өнгөрсөн. Галданбошигтын тухай ярихдаа Эрээний нуруу гэж хэлсэн. Эрээний нуруу гэж эндээ аль зүгт хаана байдаг газар юм бол?

Даваа:Эрээний нуруу гэдэг маань Өвөрхангай нутагт байдаг. Манай энэ хийдээс харагдаж байгаа нэг тийм хөхөрсөн сайхан нуруу бий. Тэрний орой дээрээс наашаа дурандахад алтан ганжуур нь харагдахад ирээд лам нарыг нь үгүй болгосон юм.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат :Бид нар Өвгөн хийд дээр очиж хэмжилт хийж үзлээ. Үлдсэн тууриудаас харахад нэлээд олон сүм дугантай байсан бололтой юм байна. Танд ийм ийм тэчнээн дугантай, лам нартай байсан юм гэсэн ам дамжсан мэдээлэл байна уу?

Даваа:Тэрийг бол сайн мэдэхгүйдээ. Ландарма бол тэр хааныг дарчаад бадар аягыг янданг нь, зүрхийг нь хар хадганд боож ирээд энэ хойд ууландаа овоо болгон тахисан юм л гэж ярьдаг юм. Тэрнээс өөр юм бол би сайн мэдэхгүй, жоохон ч байсан даа.

Монголын буддын шашны түрүү үеийн төлөөлөл Өвгөн хийдийн талаар мэдээлэл өгсөн танд баярлалаа.

Мөнхбат: Манай багийн судагааны ажил мөн Хөгнөхаан уулын бэлд орших Эрдэнэхамбын хийдийн орчмоос үргэлжлүүлж байна. Бидний сонирхосон асуултанд хариулт өгөхөөр орчин цагийн Эрдэнэхамбын хийдийг санаачлан, үүсгэн байгуулагч Даваа гуайтай ярилцлагаа үргэлжлүүлж байна. Таны байгуулсан тахил хүж зулыг нь таслахгүй авч яваа энэ Эрдэнэхамбын хийдийн гарал үүсэл 13-р зуунтай ч холбогдохоор анхны Өвгөн хийд, явсаар Манж Чин улсын үед Галданбошигтын хөнөөлд орсон дараа нь сэргээгдэж байж байгаад 20-р зууны эхний хагаст 1937,38 оны үед Буддизмыг устгаж байх үед бас устгагдсан. 3 удаагаа энэ 90 оны шинэ цагийн үеээс дахин сэргээгдээд байгаа ийм хийд. 1994 онд энэ хийдийг сэргээн босгох санаа яаж төрсөн, ямар бэрхшээл байсан, санхүүжилт нь хаанаас гарсан, дэг жаягийг нь сэргээхэд ямар бэрхшээл гарч байсан, яаж давж гарсан талаар мэдээлэл өгнө үү?

Даваа: Би өвөг эцгийнхээ захиасыг үргэлж санаж явсан. Хэзээ нэгэн цагт сангийн утаа гарна гэсэн болохоор хэзээ нэгэн цагт утаа гарах байхаа гээд дотроо бодоод явтал. Ингээд ардчилал гараад Улаанбаатар хотоос энэ хийдийг сэргээнээ гээд ирсэн. Энд ирээд хүн амьтан ч байхгүй чулуу модыг нь хэмхлээд авсан балгасууд л байсан. Энэ Чингис гэж миний хүү барилгын мэргэжилтэй тэрийгээ дагуулж ирээд барьж эхлэсэн. Эхлээд өөрийнхөө юмаар босгоход хүнд л байсан гэхдээ яахав хүн хийж байгаа ажилдаа дуртай болохоор хүнд хэцүү гэдэггүй юм байна лээ. Чулуу мод эвлүүлж байгаад энэ 3 дуганыг барьсан.

Мөнхбат: Тэгэхлээр Өвгөн хийд анх байгуулагдаж байхад нь бурхан шашны нэр нь Дашжанчивлин энэ таны шинэ цагт босгосон хийдийн нэр нь Эрдэнэхамбын хийд. Энэ Эрдэнэхамбын хийд гэдэг нь бас сонин нэр. Эрдэнэхамба гэдэг хүн бол бурхан шашны түүхэн томоохон байр суурь эзлэж байсан тухайн үеийн өндөр боловсролтой хүн байжээ. Энэ хүний тухай ярьж өгөөч?

Даваа: Эрдэнэхамба бол Завхан аймгийн хүн. 5 настай байхад нь Богд ширээнд залсан юм байна лээ. Тэрнээс хойш явсаар байгаад насан эцэс болоод Улаанбаатарт нас барсан. Тэгээд шарилыг нь нааш нь үхэр тэргээр авчирч Цэцэрлэгийн аманд шарилыг нь хайлж оршуулсан. Тэр бол Ямандагийн бөрлөө байсан гэдэг юм байна лээ. Тэгээд бие дээгүүр нь Ямандагийн тарни гарсан байсан гэж ярьдаг би жоохон байсан. Завхан аймгийн Түдэвтэй сумын Содномдоржийн 1-р хөвүүн гэж ярьдаг юм байна лээ энэ хүнийг. Тэр алдартай сайхан эрдэмтэн хүний нэрийг өгье дөө, Жанчивлан маань 2 дахин нурчихлаа, дахиад нураахгүй гэж бодогдож тэр эрдэмтэй хүний нэрийг өгсөн юм.

Мөнхбат:Хийд бол харьцангуй байнгын ажиллагаатай та өөрөө түрүүн бас хэлж байсан өдөр тутмын цогчин уншлагаа уншаад явдаг, дүйчсэн өдрүүдэд бас хуралаа хурдаг гэж байсан. Хийдийг аялал жуулчлалын үзмэр болгосоох гадна, буддын шашны дэг жаягийн дагуу хурал номыг нь таслахгүй авч явахын тулд лам нарыг нь тогтвор суурьшилтай болгохын тулд хойч үеээ бэлтгэх тал дээр яаж ажиллаж байна вэ?

Даваа: Энэ ч яахав дээ дээд сургууль төгсөөд, миний отгон хүү чинь лам хүн шүү дээ, Гэрэлтод гээд одоогоор бол Англи хэдэн жил яваад хэл сураад ирье гээд явсан байгаа, намраас ирэх байхаа. Ач

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хүү бас лам, тэгээд бас 2,3 лам гандан дээр сууж байдаг юм. Цаашдаа надаас хамаарахгүйгээр тэд нар, ламтай л гэж бодож байна даа. Цаашид нь аваад явах байх гэж бодож байна. Энд байж байгаад хурж байгаад явсан л даа.

Мөнхбат:Монголын шарын шашны томоохон хүрээ хийдийн гал голомтыг өнөө цагт сэргээн босгосон таны буяны ариун цагаан мөр өлзийтэй байх болтугай. Урт наслаж удаан жаргаарай.

Даваа:Та бүхэнд баярлалаа, тэр ерөөл бат сайхан оршигээ.